


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

07.20 - 07.24



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт холимог үзүүлэлттэй хаагдлаа. Сүүлийн саруудад зах зээлийн үнэлгээ ихтэй компаниудын хувьцаанууд (large-caps) болон өсөлтийн хувьцаануудад (growth shares) "байр сууриа алдаад" байсан, дунд зэргийн зах зээлийн үнэлгээтэй компанийн хувьцаанууд (mid-caps) болон үнэ цэнгийн хувьцаануудын (value stocks) сэргэлт энэ долоо хоногт дахин үргэлжиллээ. Apple компани болон зарим нэг компьютерын чип үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш буурсантай холбоотой технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq индекс бууралттай хаагдаж, S&P 500 индексэд технологийн салбар хамгийн их уналттай байсан бол газрын тосны үнийн өсөлттэй холбоотой эрчим хүчний салбар хамгийн их өсөлттэй байлаа.

Коронавирусийн вакцинтай холбоотой сайн мэдээ гарсан нь энэ долоо хоногийн өсөлтийн нэг шалтгаан байлаа. Oxford их сургууль болон AstraZeneca нарын хамтран гаргаж буй вакциныг 1,077 хүн дээр туршихад, тэдний бие дэх эсрэг биет болон Т-эсийн хэмжээ эрүүл түвшинд хүрсэн байна. Бээжингийн Биотехнологийн Их Сургуулийн туршилт мөн зарим нэг өвчтөнүүдэд бага хэмжээний гаж нөлөө үзүүлснээс бусдаар дархлааг дэмжиж амжилттай үр дүнд хүрсэн байна.

Европ: Европын Холбооны зүгээс эдийн засгийг дэмжих хөтөлбөрийг баталсан болон корона вирусийн вакцины таатай мэдээтэй холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байсан ч АНУ болон БНХАУ-ын харилаа муудсантай холбоотойгоор эргээд унасан байна. STOXX Europe 600 индекс 1.17%-аар, DAX индекс 0.23%-аар, CAC 40 индекс 1.47%-аар, FTSE MIB индекс 1.25%-аар, FTSE 100 индекс 2.38%-аар тус тус буурсан байна.

5 өдөр хуралдсаны эцэст Европын Холбооны удирдагчид 750 тэрбум еврогийн хэмжээтэй эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг баталжээ. Үр дүнд нь Европын Комисс, хөрөнгийн зах зээл дээр Европын 27 улсыг төлөөлж хөрөнгө босгох боломжтой болж байна. Эдийн засгийг сэргээх сан нь 390 тэрбум еврог буцалтгүй тусламж хэлбэрээр, харин 360 тэрбум еврог бага хүүтэй зээл хэлбэрээр гаргах ба одоогийн байдлаар Итали улс хамгийн их хэмжээний тусламж авахаар байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт харьцангуй тогтвортой байлаа. Пүрэв болон Баасан гарагт амралтын өдөр тохиосонтой холбоотой зах зээл хаалттай байлаа. Nikkei 225 индекс Лхагва гарагт 55 пункт буюу 0.24%-аар өсөж 22,751.61 болсон нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 3.8%-аар бага байгаа юм. TOPIX индексүүдийн хувьд large-сар буюу томоохон компаниудын хувьцааны индекс буурч, small-сар буюу жижиг компаниудын хувьцааны индекс өссөн байна.

БНХАУ: Энэ долоо хоногт БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. CSI 300 индекс 0.87%-аар, Shanghai Composite индекс 0.54%-аар тус тус буурчээ. Баасан гарагт АНУ-ын эрх баригчид БНХАУ-ын консулын газрыг Техас мужийн Хьюстон хотод үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон мэдээ гарснаар хоёр талын харилцаа хурцадмал байдалд шилжсэн ба шинжээчид БНХАУ-ын эдийн засгийн өсөлт хэврэг болж байна гэж дүгнэж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,494.07	-0.30% ▼
Dow Jones	АНУ	26,469.89	-0.76% ▼
S&P 500	АНУ	3,215.63	-0.28% ▼
Nasdaq	АНУ	10,363.18	-1.33% ▼
S&P/TSX	Канад	15,997.06	-0.78% ▼
FTSE 100	Их Британи	6,123.82	-2.65% ▼
S&P/ASX 200	Австрали	6,024.00	-0.16% ▼
Nikkei 225	Япон	22,751.61	0.24% ▲
Hang Seng	Хонг Конг	24,705.33	-1.53% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	109.95
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.63
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.65
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.54
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.76
DBM' 2023	USD	7.250%	101.75
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	90.44

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.173	-0.04 ▼
Libor 3M	0.247	-0.09 ▼
Libor 6M	0.319	-0.05 ▼
Libor 1YR	0.460	-0.02 ▼
US 2YR Bond	0.147	0.03 ▲
US 3YR Bond	0.167	-0.03 ▼
US 5YR Bond	0.274	-0.01 ▼
US 10YR Bond	0.591	-0.05 ▼

Валютын ханш	2020.07.24	Өөрчлөлт
USD	2,842.11	0.27% ▲
CNY	404.84	-0.02% ▼
EUR	3,296.28	2.09% ▲
RUB	39.69	0.51% ▲
KRW	2.36	0.43% ▲
JPY	26.76	1.13% ▲
CAD	2,115.77	1.38% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,902.02	5.06% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	22.77	17.79% ▲
Зэс	USD/lb.	289.25	-0.41% ▼
Нүүрс	USD/MT	53.32	-1.75% ▼
WTI газрын тос	USD/bbl.	41.29	1.72% ▲
Brent газрын тос	USD/bbl.	43.34	0.46% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	1.81	5.23% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VI	2.80%
Бодлогын хүү	2020.VI	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VI	8.95%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VI	10.98%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VI	4.33%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VI	17.03%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VI	10.43%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 44 компанийн 1,635.6 сая төгрөгийн 1,762,922 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Стандарт агригалчер групп” /MSE: SOH/ компанийн хувьцаа 44.74%-аар буюу хамгийн ихээр өсөж 55.00 төгрөг хүрч хаагдсан бол “Шарын гол” /MSE: SHG/ компанийн хувьцаа 29.17%-аар буурч 850.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 249.4 сая төгрөгийн 2,492 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

7-р сарын 24-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,493.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,494.07 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.30% -аар буурсан байна.



Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	7	702,780	101,390	100,000	52	17%
2	LNBO-BD-19/06/21-C0008-17	2,480	248,024,760	100,010	100,000	52	17%
3	LNBO-BD-19/06/21-C0008-17	3	300,000	100,000	100,000	52	17%
4	LNBO-BD-19/06/21-C0008-17	4	402,000	101,000	100,000	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	1,885.01	
Зах зээлийн үнэлгээ	2,493,436.32	
Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,494.07	-0.30% ▼
MSE I индекс	7,934.72	-0.12% ▼
MSE II индекс	7,419.84	-0.67% ▼
Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Инвекор ББСБ	678,159	1,454,262,147
АПУ	84,210	46,121,227
Эрдэнэ ресурс девелопмент корп	40,847	32,278,802
Ард санхүүгийн нэгдэл	16,493	20,237,233
Говь	82,232	15,187,674
Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Стандарт агригалчер групп	55.00	44.74% ▲
Түшиг уул	690.00	15.00% ▲
Улаанбаатар хивс	19,500.00	14.71% ▲
Талх чихэр	12,450.00	13.18% ▲
Адуун чулуун	1000.00	11.11% ▲
Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Шарын гол	850.00	-29.17% ▼
Улсын их дэлгүүр	930.00	-15.07% ▼
Баянтээг	21,260.00	-14.96% ▼
Шивээ овоо	1,900.00	-14.41% ▼
Улаансан	735.00	-11.45% ▼
Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)	
Инвекор Капитал	2,876,942,477.50	
БиДиСек	99,814,269.53	
Ти Ди Би Капитал	69,139,167.20	
Ард Секюритиз	67,076,182.58	
Стандарт Инвестмент	28,558,248.71	
Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	548.55	583,757
Таван толгой	5,520.00	290,712
МИК холдинг	12,990.00	269,014
Инвекор ББСБ	2,519.00	180,683
Говь	185.00	144,321

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө татан төвлөрүүлэх, шинээр үнэт цаас гаргах үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 22-р зүйлийн 22.2.2 дахь заасан үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг 2020 оны 7-р сарын 1-ний өдрөөс 2020 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 20%-аар хөнгөлөхөөр боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангаа ирүүлээгүй компаниудын анхааралд.

Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компани нь “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 20-р зүйлийн 20.1.6, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 10-р зүйлийн 10.3 дахь заалтад заасны дагуу хагас жилийн санхүүгийн тайланг 7-р сарын 20-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх үүрэгтэй байдаг билээ. Энэ хугацаанд нийт бүртгэлтэй 199 хувьцаат компаниас нэр бүхий 59 компани нь олон нийтэд нээлттэй, ил тод байх компанийн засаглалын сайн жишгийг хангаж МХБ-д санхүүгийн тайлангаа ирүүлээд байна.

Хуульд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй буюу хагас жилийн санхүүгийн тайлангаа ирүүлээгүй нэр бүхий хувьцаат компаниуд 2020 оны 8-р сарын 1-ний өдрийн дотор зөрчлийг арилгаагүй тохиолдолд СЗХ-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам”, МХБ-ийн холбогдох журмууд болон “Бүртгэлийн гэрээ”-нд заасны дагуу хариуцлагын арга хэмжээг ногдуулахыг анхааруулж байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК хаалттай санхүүжилтийн хүрээнд 20 сая кан. долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлээ.

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /TSX: ERD, MSE: ERDN) ХК хаалттай санхүүжилтийн хүрээнд 20 сая кан.долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж байгаа бөгөөд үүний хүрээнд ноён Эрик Спротт 15 сая кан.долларын хөрөнгө оруулж, санхүүжилтийн багцын тэргүүн захиалагч болсон байна.

Энэхүү санхүүжилтийг анхан шатны бүтээн байгуулалт, өндөр агуулга бүхий нөөцийг тэлэх хайгуулын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулна хэмээн компанийн зүгээс мэдэгдсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК Баян Хөндий Алтны Төслийн эцсийн ТЭЗҮ-г танилцуулав.

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /TSX: ERD, MSE: ERDN) ХК Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус эцсийн Техник Эдийн Засгийн Үндэслэлийн үр дүнг танилцууллаа.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц, мөн 3.71 г/т дундаж алтны агуулга бүхий 409,00 унц батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөцийг тогтоосон. Төслийн үргэлжлэх хугацаа нийт 8 жил бөгөөд энэ хугацаанд татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэнэ (5% хорогдуулалт бүхий) 100 сая ам.доллар болон дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон нь өнөөдрийн алтны ханшид (1,800 ам.поллар/унц) тулгуурлан тооцвол тус бүр 215 сая ам.доллар болон 77% болж өсөхөөр байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Талх чихэр” /MSE: TCK/ ХК энэ оны эхний хагас жилд нэгж хувьцаанд 799.24 төгрөгийн ашиг олов.

Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны I ангилалд бүртгэлтэй “Талх чихэр” /MSE:TCK/ ХК 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаа танилцууллаа.

Тайлангийн үзүүлэлтийг харвал борлуулалт болон ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс өсөлттэй гарсан байна. Үүнд компанийн орлого 28.8 тэрбум төгрөг буюу 2019 оны эхний хагас жилийн дүнгээс 13.9%-аар өсжээ. Цэвэр ашиг 818.18 сая төгрөг байгаа ба нэгж хувьцаандаа 799.24 төгрөгийн ашиг олсон байна.

Эх сурвалж: MarketInfo.mn


ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.4 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 4.1 их наяд төгрөг байна. Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь нийт орлогын 94.1%-ийг эзэлж байна.

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны 6-р сард 794.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 97.7 (14.0%) тэрбум төгрөгөөр өсөж, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 226.0 (14.1%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Инфляцид үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө эрчимжихээргүй байна. Инфляци улсын хэмжээнд 2020 оны 5-р сард 3.3%, Улаанбаатар хотод 3.5%-д хүрч сүүлийн 4 сар дараалан буурав. Эрэлтийн талаас Төв банк, засгийн газраас авч хэрэгжүүлж буй хэрэглээг дэмжих арга хэмжээнүүд нь инфляцид эерэг нөлөө үзүүлэх хэдий ч КОВИД-19-ийн сөрөг нөлөө давамгайлж байна. Нийлүүлэлтийн хүчин зүйлсийн хувьд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийг даган дотоодын шатахууны үнэ 4-р сард дунджаар 300 төгрөгөөр хямдарсан бол 5-р сард дахин 100 орчим төгрөгөөр буурав. Түүнчлэн, нөөцийн махны хэмжээ нэмэгдсэн, махны экспортыг хязгаарласан нь сүүлийн саруудад махны нийлүүлэлт тогтвортой байхад эерэг нөлөө үзүүлж байна. Цаашид нийлүүлэлтийн шалтгаантай үнийн огцом хэлбэлзэл үүсэхгүй гэж үзвэл инфляц 2020-2021 оны туршид инфляцын зорилтот түвшнээс бага байх төлөвтэй байна.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 6.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 их наяд төгрөгөөр буюу 22.5%-аар буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.6 их наяд төгрөгөөр буюу 26.9%-аар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 279.6 тэрбум төгрөгөөр буюу 15.7%-аар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 14.0 тэрбум төгрөгөөр буюу 2.3%-аар өссөн байна.


Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 их наяд төгрөгөөр буюу 26.9%-аар буурахад нүүрс олборлолт 1.5 их наяд төгрөгөөр буюу 54.6%-аар, газрын тос олборлолт 382.0 тэрбум төгрөгөөр буюу 76.0%-аар, металлын хүдэр олборлолт 172.0 тэрбум төгрөгөөр буюу 6.1%-аар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 6-р сард 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 176.1 тэрбум төгрөгөөр буюу 15.1%-аар өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 144.4 тэрбум төгрөгөөр буюу 17.7%-аар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 40.7 тэрбум төгрөгөөр буюу 15.7%-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2020 оны эхний хагас жилд алт болон төмрийн хүдэр олборлолт өмнөх оны мөн үеэс 15.9-42.4 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт спирт, гурил, ус, ундаа, шүүс, шингэн сүү зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7.6-14.2 хувиар тус тус өссөн байна. Мөн хаалтын шахмал түлш болон амны хаалтны үйлдвэрлэл 2020 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 3.0-21.0 дахин өссөн байна.


Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН


МОНГОЛ УЛСЫН ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭС



Эх сурвалж: Дэлхийн банк, Гаалийн ерөнхий газар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тунгаасан зэс хайлшийн үнэ (Катодын зэс) нь олон улсын зах зээлийн үнэтэй нийцэж байгаа бол Зэсийн хүдэр, баяжмалын экспортын үнэ зах зээлийн үнээс 4-6 дахин бага байна.

Гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээллээс харвал 2020 оны эхний 6 сарын байдлаар зэсийн хүдэр, баяжмалын экспорт 675.9 мянган тоннд хүрч өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 9.8%-аар буурсан байна. Экспортын үнийн дүн 741.1 сая ам.доллард хүрч 30.2%-аар буурчээ.

Тунгаасан зэс ба хайлшны экспорт 5.7 мянган тоннд хүрч 25.4%-аар өссөн бол үнийн дүн 30.8 сая ам.долларт хүрч 12.6%-аар буурсан байна.

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.